

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Нэг. Ерөнхий зүйл

Хүнд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлав.

Хуулийн төсөл нь хүнд үйлдвэрлэлийг дэмжих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэхтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тооцсон болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг тандан судлах явцад тус тус гүйцэтгэнэ.

Энэ нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

Хоёр. Иргэн, хуулийн этгээд, хувь хүнд үүсгэх зардал

Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл дэх зохицуулалтууд нь иргэн, төрийн байгууллагад нэмэлт зардал үүсгэхгүй.

Харин хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотойгоор зарим зардал гарахаар байна. Үүнд:

“Хүнд үйлдвэрлэлийг үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт, зөвлөмж гаргуулж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэн, энэ хуулийн 14.1.4-д заасан тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ”, “нэвтрүүлсэн, нутагшуулсан технологи, эзэмшиж байгаа патент, лиценз, судалгаа, хөгжлийн ажлын үр дүн болон бусад технологийн шинэчлэлийн талаарх мэдээллийг тухай бүр мэдээллийн санд бүртгүүлэх”, “Засгийн газраас олгосон зээл бусад дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зарцуулалтын явц, үр дүнг жил бүр хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” зэрэг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой зардлын тооцооллыг гүйцэтгэв. Нэг аж ахуйн нэгжид дунджаар 302,5 мянган төгрөгийн зардал гарахаар байгаа бөгөөд үүний ихэнх нь улсын тэмдэгтийн хураамж хэлбэрээр улсын төсөвт төвлөрнө. Тооцооллийг хавсаргав.

Гурав. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Хүнд үйлдвэрийг байгуулж, хөгжүүлэх эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлснээр нийгэм, эдийн засагт дараахь нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- ✓ Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын үйлдвэрийн өрсөлдөх чадвар нэмэгдэнэ
- ✓ Импортын хэмжээ буурч, гадаад худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэнэ.
- ✓ 5000 гаруй ажлын байрыг шинээр бий болгоно
- ✓ Хүнд үйлдвэр дагасан үйлдвэрүүд олноор бий болж, технологийн шинэчлэл хийгдэнэ.
- ✓ Хүнд үйлдвэрийн томоохон төслүүд хэрэгжих хугацаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, шинэ техник, технологи нэвтэрнэ.
- ✓ Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэмэгдэнэ.
- ✓ Олон тулгуурт эдийн засаг хөгжих нөхцөл бүрдэнэ.
- ✓ Экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, импортыг орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.

АЖ АХУЙН НЭГЖИД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг) (Ажлын хөлс, цагаар)	Тоон үзүүлэлт (Аж ахуйн нэгжийн тоо)	Нийт зардал (төг)
Хүнд үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авах	Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	Өргөдөл бичих	790.3	75	5 9272.5
	Улсын бүртгэлийн гэрчилгээ	Гэрчилгээнд өөрчлөлт хийлгэх	564.5 10000 хураамж	75	792 337.5
	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	Тэмдэгтийн хураамж төлөх	40000*18 200000*50 80000*5 800000*2	75	19 200 000
	Тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг	Баримт бичиг боловсруулах, олшруулах	3 387	75	254 025
	Барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авах	Тодорхойлолт гаргуулах	3 387	75	254 025
Судалгаа, хөгжлийн ажлын үр дүн болон бусад технологийн шинэчлэлийн талаарх мэдээллийг санд бүртгүүлэх	Мэдээллийг тухай бүр нэгтгэн шинэчлэх	Мэдээллийг бэлтгэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	19 872.2	75	1 490 415
Засгийн газраас олгосон зээл	Тайланг гаргах	Тайланг нэгтгэж, Төрийн	8516.6	75	638 745

бусад дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зарцуулалтын явц, үр дүн тайлагнах		захиргааны төв байгууллагад хүргүүлэх			
Нийт зардал					22 688 820